

**“МТЗ”ТӨХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАНГИЙН БИЕЛЭЛТ**

2.6. Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт: Хэрэгжилт хангалтгүй буюу 30 болон 0 хувийн үнэлгээтэй арга хэмжээ:

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
1	1.9. Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс хойш зүгшрүүлэх тээвэрлэлт хийсэн статистик мэдээллийг цахим хуудас дахь Ил тод байдлын цэсэнд нийтэлсэн.
2	2.4. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам	"Монголын төмөр зам" ТӨХК-ийн Хүний нөөцийн бодлогын баримт бичгийг цахим хуудсанд нийтэлсэн.
3	2.5. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	<p>Хүний нөөц буланд:</p> <ul style="list-style-type: none"> - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон Гүйцэтгэх захирлын овог нэр - холбоо барих цахим хаяг - ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх захирлаар томилогдсон он сар өдөр - ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах зар - ТӨБЗГ-аас томилсон тушаал шийдвэр - Цалин урамшууллын мэдээллийг нээлттэй ил тод байршуулсан. <p>Мөн компанийн удирдах албан тушаалтнуудын:</p> <ul style="list-style-type: none"> - овог нэр - албан тушаал - утас - ажилд томилогдсон он сар өдөр гэсэн мэдээллүүдийг тухай бүр шинэчлэн нийтэлж байна.
4	3.9. Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл	ОНХА-д хамааралгүй.
5	3.10. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан	<p>Цахим хуудас дахь Ил тод байдлын буланд</p> <ul style="list-style-type: none"> - 2022 оны хагас жилийн бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтын тайлан - Үндэсний үйлдвэрлэгчээс бараа ажил үйлчилгээ худалдан авсан хагас жилийн тайлан - Худалдан авалтад хийсэн аудитын дүгнэлт 2022 оны 02 дугаар дугаар улирал - Тендерийн урилга /2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс хойш тендер зарлаагүй/ - Тендерийн сонгон шалгаруулалт, үр дүн /2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар/ тус тус нийтэлсэн.

6	3.13. Төсвийн хөрөнгөөр болон гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн	Төсвийн хөрөнгөөр санхүүжиж буй: - “Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн 416,1 км төмөр замын танилцуулга, явц - Замын-Үүд дэх Бүс нутгийн логистик төвийн үйл ажиллагааны танилцуулга, явцын талаар мэдээ мэдээллийг цахим хуудаст нийтэлсэн. Санхүүжилтийн мэдээлэл нь төрийн нууцад хамаарна.
7	3.15. Хууль тогтоомжид заасан бусад	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8-р бүлгийн компанийн үйл ажиллагаанд хамааралтай дараах мэдээллийг цахим хуудаст нийтлэсэн. 8.6.1 Олон нийтээр хэлэлцүүлж санал авах хууль тогтоомж, хуулийн төсөл одоогоор байхгүй. 8.6.2 Компанийн албан хэрэгцээний documents программын Оюуны өмчийн эрхийн гэрчилгээг цахим хуудаст байршуулсан. 8.10 Худалдан авалтад хийсэн аудитын дүгнэлт 2022 оны хагас жил, худалдан авалт болон санхүүгийн хагас жилийн тайлан, нээлттэй ажлын байрны мэдээллийг нийтэлсэн. 8.13 Нээлттэй мэдээллийн талаар нэмэлт мэдээлэл авах утас хаяг болон онлайн чатыг цахим хуудаст нийтэлсэн. 8.6.21 Компанийн зардлаар суралцагчдын мэдээллийг цахим хуудаст байршуулсан.
8	5.4. Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл	Цахим хуудас дахь Бидний тухай буланд Компанийн эзэмшлийн газруудын мэдээллийг нэгтгэн оруулсан.